131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	274,856.06
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	86,439.47
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	26,570.02
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,570.02

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн

тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 03-ний өдрийн 01/86 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бүрэгхангай сумын эрхэм зорилго нь “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, ажлын байр, иргэдийн амьдрах орчин, амьжиргаа дэмжих” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Унианг, хожуул, гишүү, Ногоон тэжээл, сайн хашаа, гудамж төслийг хэрэгжүүлэх
- Ажлын байрыг нэмэгдүүлэх
- Иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулах
- 1км бетонон замыг тавих, замын суваг шуудуу янзлах
- Гэр, хорооллуудын гэрэлтүүлэг, хүүхдийн тоглоомын талбайг нэмж засварлах, барих
- Үүрэн холбооны сүлжээг өргөтгөх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 5,147,063.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 102,941.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 70,058.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЙЛБАР, ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 707,129.9 мянга, эцсийн үлдэгдэл 1,266,838.0 мянган төгрөг болж, 559,708.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл (мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	707,129.9	1,240,268.0	533,138.1	95.3
Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	26,570.0	26,570.0	4.7
Дүн	707,129.9	1,266,838.0	559,708.1	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 1,266,838.0 мянган төгрөг төрийн сангийн ерөнхий дансанд байршиж байна. Үүний сумын ерөнхий орлогод 541,762.6 мянга, орон нутгийн хөгжлийн санд 374,472.1 мянга, сум хөгжүүлэх санд 66,462.4 мянга, байгаль хамгаалах санд 216,706.7 мянга, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санд 11,456.0 мянга, эрүүл мэндийн төвд 29,408.2 мянган төгрөг байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 208,119.5 мянга, эцсийн үлдэгдэл 351,408.5 мянган төгрөг болж, 143,289.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл (мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Татаас, санхүүжилтийн авлага		88,565.0	88,565.0	61.8
Байгууллагаас авах авлага	25,089.1	103,027.7	77,938.6	54.4
Хувь хүмүүсээс авах авлага	183,030.4	159,815.8	(23,214.6)	(16.2)
Дүн	208,119.5	351,408.5	143,289.0	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 85,822.9 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангаас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон 17 зээлдэгчийн 74,703.5 мянган төгрөг,
- ЖДҮДС-аас жижиг дунд бизнес эрхлэгчийг дэмжих зорилгоор олгосон зээлийн 10,022.0 мянган төгрөг,
- Сумын ЗДТГ-ын олон жилийн өмнө үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй хувь хүнээс авах 1,097.4 мянган төгрөг,

Эдгээр нь жижиг дунд үйлдвэрлэл хөгжихгүй, ажлын байр нэмэгдэхгүй, сангийн хөрөнгө багасах, зээлийн эргэлт удаашрах үр дагавартай байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 236,114.5 мянга, эцсийн үлдэгдэл 263,567.3 мянган төгрөг болж, 27,452.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл (мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	18,692.19	18,143.87	5,237.10	19.08
Эм боох материал	-	115,845.58	46,969.90	171.09
Бэлэн бүтээгдэхүүн	7,258.48	907.71		
Бичиг хэргийн материал	6,871.06	7,567.40	(1,849.90)	(6.74)
Аж ахуйн материал	111,391.49	109,543.88	(22,106.80)	(80.53)
Сэлбэг хэрэгсэл	4,311.40	-	(380.00)	(1.38)
Түлш, шатах тослох материал	11,721.11	12,927.46	2,020.00	7.36
Барилгын засварын материал	31,834.46	6,087.06	2,814.00	10.25
Хүнсний материал	26,013.74	12,172.41	(4,668.70)	(17.01)
Бусад хангамжийн материал	158,870.95	175,578.15	(582.60)	(2.12)
Биологийн хөрөнгө	-	1,075.36	-	-
Дүн	236,114.40	263,567.40	27,453.00	100

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авсан 57,041.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, эм боох материал, түлш, шатах тослох материал, барилгын засварын материалыг тухайн төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж төсөв үлдсэн шалтгаанаар нөөцөлсөн.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,576,701.9 мянга, эцсийн үлдэгдэл 6,872,065.2 мянган төгрөг болж, 295,363.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл (мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга, байгууламж, орон сууц	5,440,854.19	5,556,354.19	(115,500.00)	39.10
Хуримтлагдсан элэгдэл	(541,579.43)	(757,818.41)	216,238.98	(73.21)
Авто-тээврийн хэрэгсэл	295,737.97	325,737.97	(30,000.00)	10.16
Хуримтлагдсан элэгдэл	(209,852.45)	(232,735.47)	22,883.02	(7.75)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	794,121.76	983,343.45	(189,221.70)	64.06
Хуримтлагдсан элэгдэл	(223,803.25)	(278,203.17)	54,399.92	(18.42)
Тавилга, аж ахуйн эд хогшил	251,394.07	302,776.33	(51,382.26)	17.40
Хуримтлагдсан элэгдэл	(88,180.73)	(108,064.88)	19,884.14	(6.73)
Зам, гүүрийн байгууламж	611,530.05	845,832.70	(234,302.65)	79.33
Хуримтлагдсан элэгдэл	(58,566.60)	(99,390.31)	40,823.71	(13.82)
Бусад үндсэн хөрөнгө	253,071.69	294,071.69	(41,000.00)	13.88
Хуримтлагдсан элэгдэл	(54,888.96)	(75,277.27)	20,388.31	(6.90)
Ном	27,872.54	27,947.54	(75.00)	0.03
Программ хангамж	3,000.00	13,650.00	(10,650.00)	3.61
Хуримтлагдсан элэгдэл	-	(908.33)	908.33	(0.31)
Бусад биет бус хөрөнгө	77,799.91	77,799.91	-	-

Хуримтлагдсан элэгдэл	(1,808.86)	(3,050.79)	1,241.93	(0.42)
Дүн	6,576,701.89	6,872,065.16	(295,363.26)	100.00

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 139,796.0 мянга, балансас балансад шилжүүлэн авсан 366,980.9 мянга, үнэ төлбөргүй хандиваар авсан 205,434.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн, акталсан 40,080.3 мянган төгрөгөөр хасагдсан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 12,560.3 мянган төгрөг болж өссөн байна.

Хүснэгт № 5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл (мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	-	12,560.34	12,560.34	100.00
Ажилчидтай холбогдсон өглөг	-	12,560.34	12,560.34	100.00
Нийт дүн	-	12,560.34	12,560.34	100.00

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Ерөнхий боловсролын сургуулийн 11,789.6 мянга, эрүүл мэндийн төвийн 770.7 мянган төгрөгийн өглөг байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,728,065.7 мянга, эцсийн үлдэгдэл 8,771,206.6 мянган төгрөг болж, 1,043,140.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо (мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,322,029.4	1,333,029.4	-	-
Хуримтлагдсан үр дүн	4,101,399.6	5,133,540.4	1,032,140.8	100.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,304,636.7	2,304,636.7	-	-
Дүн	7,728,065.7	8,771,206.5	1,032,140.8	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,133,540.4 мянган төгрөг болж 1,032,140.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Бүрэгхангай сумын ИТХ-ын “2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 04/03 дугаар хуралдааны тогтоолоор татварын ба татварын бус орлогыг 596,305.0 мянган төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 601,170.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн, орлогын төлөвлөгөөг 4,864.8 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 7. Сумын төсвийн орлого (мянган төгрөг)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	УРСГАЛ ОРЛОГО	596,305.40	601,170.10	4,864.70	100.82
11	ТАТВАРЫН ОРЛОГО	571,595.40	556,210.20	(15,385.20)	97.31
110	Орлогын албан татвар	55,500.00	62,401.29	6,901.29	112.43
1100	Хувь хүний орлогын албан татвар	55,500.00	62,401.29	6,901.29	112.43
110002	Үйл ажиллагааны орлого	500.00	25,167.79	24,667.79	5,033.56
110003	Хөрөнгийн орлого	25,000.00	36,351.71	11,351.71	145.41
110008	Шууд бус орлого	30,000.00	881.80	(29,118.20)	2.94
113	Хөрөнгийн албан татвар	172,084.00	154,831.50	(17,252.50)	89.97

113002	Бууны албан татвар	4,084.00	3,342.00	(742.00)	81.83
113004	Малд ногдуулах албан татвар	168,000.00	151,489.50	(16,510.50)	90.17
118	Бусад татвар, төлбөр, хураамж	344,011.40	338,977.40	(5,034.00)	98.54
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,500.00	17,610.08	2,110.08	113.61
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4,000.00	2,466.10	(1,533.90)	61.65
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	3,500.00	2,000.00	(1,500.00)	57.14
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,000.00	13,143.98	5,143.98	164.30
1181	Газрын төлбөр	300,000.00	281,933.75	(18,066.25)	93.98
118101	Газрын төлбөр	300,000.00	281,933.75	(18,066.25)	93.98
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	28,511.40	39,433.57	10,922.17	138.31
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	3,511.40	3,683.57	172.17	104.90
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	25,000.00	35,750.00	10,750.00	143.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,710.00	44,959.90	20,249.90	181.95
120	Нийтлэг татварын бус орлого	24,710.00	44,959.90	20,249.90	181.95
120002	Хүүгийн орлого	18,000.00	33,927.50	15,927.50	188.49
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	710.00	1,004.00	294.00	141.41
120005	Түрээсийн орлого	1,000.00	973.00	(27.00)	97.30
120009	Бусад орлого	5,000.00	9,055.40	4,055.40	181.11

Зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөө биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлого сонгуулийн жилтэй холбоотой хувь хүний орлогын албан татвар, ноолуурын урамшууллын орлого нэмэгдсэн,
- Хөрөнгийн орлого Хаан болон Төрийн банкны хадгаламж ээмшигч нэмэгдсэн,
- Усны төлбөр болон ус рашаан ашигласны төлбөр бичил уурхайнууртэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж эхэлсэн,
- Ойн нөөц ашигласны төлбөр 2021 онд хошуул, унианг төсөл хэрэгжүүлсэн,
- Хог хаягдлын төлбөр ЗГ-ын тогтоолоор иргэд, ААНБ-ын хог хаягдал үйлчилгээний төлбөрийг иргэдээс хөнгөлж, улсаас төлсөн, бичил уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй тус тус холбоотой байна.

Харин зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөө тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Малын хөлийн тоо толгойн албан татвар малын гоц халдварт шүлхий өвчин гарч хөл хорио тогтоосон,
- Бууны албан татвар Цагдаагийн газар, Татварын газрын бүртгэл зөрүүтэй, нас барсан иргэдийн бүртгэлд хугацаандаа хасалт хийгддэггүй,
- Газрын төлбөр Би Би Жи Эн ХХК,, Нүүдэлчин айрон ресорс ХХК, Ориент майнинг инвестмент ХХК, Эрхэс майнинг ХХК зэрэг аж ахуй нэгжүүд 2021 оны газрын төлбөрийг төлөөгүй,

- Шууд бус орлого Ковид-19 цар тахалтай холбоотой ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагаа явагдаагүй түр зогссон, жижиг дунд бизнес эрхлэгч хялбаршуулсан горимоор буюу 1 хувиар татвар төлдөг болсон,
- Улсын тэмдэгтийн хураамж Ковид-19 цар тахал, Малын гоц халдварт өвчин гарч хол хорио тогтоогдсоноос нотариат, улсын бүртгэлийн үйлчилгээ зогссон,
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг элс, хайрга олборлох зөвшөөрөлтэй карьер байхгүй, орлогыг бодитой төлөвлөөгүй зэргээс тус тус тасарсан байна.

3.5 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Бүрэгхангай сумын ИТХ-ын хуралдааны тогтоолд төсөвт байгууллагын өөрийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас, гүйцэтгэлээр 294.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	(мянган төгрөг)			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын тамгын газар	710.0	1,004.0	294.0	141.4
Соёлын төв	800.0	800.0	-	-
ДҮН	1,510.0	1,804.0	294.0	100.0

Эх сурвалж: Бүрэгхангай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,509,130.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,509,130.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 4,509,130.0 мянган хэвээр баталж, тайлант онд төсөвт 1 удаа өөрчлөлт оруулан, 4,694,922.6 мянган төгрөг буюу 185,792.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 4,690,550.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 4,316,717.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 234,739.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 139,094.1 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,336,109.8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,394,055.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 25,202.8 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,935,182.5 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,275,162.8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,119,763.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 11,824.1 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас нийт 3,192,259.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 1,498,291.1 мянган төгрөгийг дутуу олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,760,551.7 мянган төгрөг буюу 62.5 хувьтай байгаа нь дараах хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Үүнд:

- Урсгал зардлын гүйцэтгэлийн материаллаг дүнтэй зардлуудын дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал, малын гоц халдварт өвчин гарсантай холбоотой хөл хорио тогтоож томилолтын болон бараа үйлчилгээний бусад зардал хэмнэгдсэн байна.
- Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 104,585.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

- Хөрөнгө оруулалтын нэг төсөл, арга хэмжээнд 234,739.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 25,500.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, ЗДТГ-ын их засварын ажил хийгдээгүйгээс орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 33,200.0 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс 189,089.1 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 274,856.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 86,439.5 мянга, нийт 583,584.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин болон нэмэгдэл урамшуулалд 60,517.9 мянга, хангамж болон бараа материалын зардалд 1,542.3 мянга, нормативт зардал 114,340.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 54,161.9 мянга, томилолт зочны зардалд 834.2 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 231,944.2 мянга, АО-оос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 25,000.0 мянга, хөрөнгийн зардалд 51,430.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,650.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.6 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 153 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Тухайлбал:

- ✓ ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл бүтэн жил,
- ✓ Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 5 сар, 4-р улирал, бүтэн жил,
- ✓ Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл бүтэн жил,
- ✓ Худалдана авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны тайланг тс тус хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1 "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"д заасантай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.7 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 87.498.9 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт (мянган төгрөг)

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт	Биелэлт	Биелэгдээгүй	
----------	---------------------	---------	--------------	--

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хэрэгжилтийн хувь
Албан шаардлага	1	-	-	-	1	-	-
Зөвлөмж	5	87,498.9	2	300.0	3	87,198.9	40.0
Нийт	6	87,498.9	2	300.0	4	87,198.9	40.0

3.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай” 2 /Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв/, дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,307,387.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 19,250.0 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 6,747.9 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,724.791.0 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 677,498.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг хүргүүллээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

3.10.1 Үндсэн хөрөнгийн эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг /өртгөө/ нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн дууссан хөрөнгөнд нэмж элэгдлийн зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

3.10.2 Нэмэлт санхүүжилтийн данс болон үндсэн үйл ажиллагааны зориулалтаас бусад арга хэмжээний зардлыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулахаар зарцуулалтын эрх олгоогүйгээс шалтгаалж, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнтэй зөрүүтэй байна.

3.10.3 Насжилт өндөртэй авлагыг барагдуулах талаар ямар нэг арга хэмжээ авч ажиллаагүй, Шилэн дансны нэгдсэн системд 153 мэдээлэл байршуулахаас 5 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй, шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, арга хэмжээ зохион байгуулан ажиллаагүйд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх шаардлагатай байна.

3.10.4 Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах, тайлагнах журмыг зөрчиж, Байгаль хамгаалах сангаас орон тоо батлаагүй байхад нэмэлтээр байгаль хамгаалагч гэрээгээр, ажиллуулж байгаа асуудлыг анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

3.11 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад тусгай сангийн дансны бичилтийг НББББ-ыг мөрдөөгүй, авлагыг хугацаагаар нь богино болон урт хугацаат авлагаар ангилж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүйгээс бодитой мэдээллээр хэрэглэгчдийг хангаж чадахгүй эрсдэл үүсч байна.

3.12 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

3.13 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- ✓ Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,
- ✓ Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 645,970.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 35,618.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 610,651.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

4.2.1 Бууны албан татвар 742.0 мянга, Мал ногдуулах албан татвар 16,510.5 мянга, газрын төлбөр 18,066.2 мянган төгрөгийн төсөвт төвлөрүүлэх ёстой татварын орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэнд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1, Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүйд төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

4.3.1 Сум хөгжүүлэх сангийн гүйлгээг бүртгэхдээ цаг хугацааны дарааллаар зээлдэгчийн хүү, алданги, авлагыг тухай бүр нь бүртгэхгүй нийт дүнгээр нь дансны бичилт хийж бүртгэсэн байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүйд албан шаардлага хүргүүлсэн.

4.3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт нийгмийн хариуцлагын гэрээний санхүүжилтээр хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтыг нэршлээр нь сумын ИТХ-аар батлуулаагүй, бөөн дүнгээр батлуулж, Засаг даргын захирамжаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4, 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг хангаж ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна"-д заасантай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдлийг хуульд заасны дагуу гаргаж ирүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Бүрэгхангай сумын Засаг дарга	4	645,970.4	-	-	1	35,318.7	2	610,651.7	1	0